



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/364

Хэрлэн сум

Зуслангийн стандартын хэрэгжилтийг үнэлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.9 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS5633:2023 стандартын хэрэгжилтийг үнэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: Х.Уртнасан

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

Гишүүд: Э.Цэнд

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн

Н.Хашхүү

Стандарт хэмжил зүйн хэлтсийн Бүтээгдэхүүн баталгаажуулалтын Мэргэжилтэн

Б.Болор-Эрдэнэ

Онцгой байдлын газрын Гал түймрийн Улсын хяналтын байцаагч, Хошууч

Г.Нямтөгс

Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Ахлах дэслэгч

Г.Бүжмаа

Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын Улсын байцаагч

2.Зуслангийн стандартын хэрэгжилтийн үнэлгээг 2024 оны 07 дугаар сарын 03-аас 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж, тайланг 2024 оны 07 дугаар сарын 09-ний дотор ирүүлэхийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Х.Уртнасан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ